ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

# 2020-2021 ОНЫ БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН ЭМХТГЭЛ

2021 он

"ШИЛДЭГ ИЛТГЭЛ 2020" шалгаруулах уралдааны тайлан,дүгнэлт

Багш нарынхаа дунд "ШИЛДЭГ ИЛТГЭЛ 2020" шалгаруулах уралдаан 2020,12,07-ны өдөр цахимаар амжилттай зохион байгууллаа. 13 илтгэл оролцож эхний 3 байрыг шалгаруулллаа. Шүүгчээр ажилласан САМ Л.Ганчимэг, МБСБ-ийн ахмад багш Л.Баасансүрэн, Ажил олгогч Б.Эрдэнэбаяр, Б.Туяа нар ажиллаа.

1-р байр. Б.Мэндбаяр 43,3 оноо

2-р байр С.Сүндэрмаа, Л.Мөнхжаргал 43,2 оноо

3-р байр А.Чулуунчимэг 41,7 оноо

4-р байр М.Баярмаа, М.Сандагсүрэн 40,8 оноо

5-р байр Ц.Мөнхцэцэг 40,5 оноо

6-р байр Л.Энхмөнх 39,2 оноотой гэх мэт үнэлгээгээ жагсаалаа. .

Манай багш нар сайхан сэдэв дэвшүүлж судалгааны ажлыг хийсэн байсан. Цаашид та хэдийнхээ дэвшүүлсэн санааг ажил хэрэгтээ тусгаж хамтран ажиллах болно.

Илтгэлийн уралдаанд багш нар маш олон зүйлийг судлан гаргаж ирсэний үр дүнд сургалтын алба дараах дүгнэлтийг гаргалаа.

1. Удирдамжийн загвар доторх агуулга нь МБС-ын 2,5 жилийн ангиуд, МБС-ын насан хүрэгчдийн 1 жилийн сургалтын ангиуд, ТБС –ын 1,5 жил 3 жилийн ангиудынх өөр хоорондоо нас сэтгэхүйн онцлогт тулгуурласан хийх ажилбар болон олж авах мэдлэг, ур чадвар, хандлагын талаар удирдамжийн хөтөлбөр нь өөр өөр байхаар шинэчлэн засварлах шаардлагатай
2. Үйлдвэрлэлийн дадлагаар олж авах мэдлэг хандлага ур чадварын хөтөлбөрийг нарийвчлан гаргаж ирэх
3. Үйлдвэрлэлийн дадлагат гарахад нь зөвлөн туслах үйл ажиллагааг СА-наас өгч байх
4. Үйлдвэрлэлийн дадлагад гарахад хариуцсан багш ажилтантай байуж ААНБ-тай холбоо харилцааг тогтоон ойр дотно харилцаатай байж хяналт тавих
5. 1 жилийн сургалтын системийг Дуаль буюу хосмог сургалтын аргаар зохион байгуурах талаар санал гарлаа.
6. Сургууль дээрх дадлагын сургалтыг чанартай гүйцэтгэх хяналтыг сайжруулах
7. ААНБ-тай хамтран ажилах гэрээндээ үйлдвэрлэлийн дадлага хийлгэх тал дээр анхаарч сайжруулалт хийж ажиллах
8. ААНБ-тай хамтын ажиллагаагаа улам бүр сайжруулах талаар дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт, тайлан бичсэн. Сургалтын арга зүйч Ц.Мягмарсүрэн

**Уул уурхайн жишиг сургууль Говьсүмбэр аймаг дахь**

**Политехник коллеж**

# **СЭДЭВ:** ОЮУТАН СУРАЛЦАГЧДЫН НАС СЭТГЭХҮЙ, БИЕ БЯЛДРЫН ОНЦЛОГ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГЫН ҮР ДҮНД НӨЛӨӨЛӨХ НЬ/МБС 2.5 жил/

**АВХҮҮ ЧУЛУУНЧИМЭГ**

**2020 он**

## Бүтэц

**Оршил хэсэг**

1. Удиртгал
2. Үндэслэл
3. Судалгааны зорилго
4. Судалгааны зорилт
5. Судалгааны аргууд

1. **Нэгдүгээр бүлэг**

**1.1.** 15-18 настай хүүхдийн хөгжлийн онцлог

**1.2.** Үйлдвэрлэлийн дадлагын гурван талт гэрээ

**1.3.** Үйлдвэрлэлийн дадлагын удирдамж дахь сургууль, эцэг эх, ажил олгогчын эрх, үүрэг

2. **Хоёрдугаар бүлэг**

**2.1.** 2010-2012 он болон 2019-2020 оны суралцагчдын насны судалгаа

**2.2.** Үйлдвэрлэлийн дадлагын бааз, хяналтын судалгаа

**2.3.** Үйлдвэрлэйин дадлагын үр дүнг тодорхойлох, тэдний нас сэтгэхүй бие бялдрын онцлогоос шалтгаалж тулгарч буй саад бэрхшээлийг нээн илрүүлэх, үйлдвэрлэлийн дадлагын чанарыг сайжруулахад сургууль, эцэг эх, ажил олгогч талаас хэрхэн эерэг нөлөө үзүүлж буйг эрэлхийлсэн судалгаа

**2.4.** Оюутан суралцагчдын нас сэтгэхүй бие бялдрын онцлогт тохирсон үйлдвэрлэлийн дадлага хийх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд сургууль, эцэг эх, ажил олгогч талаас хэрхэн үр дүнтэй ажиллах шийдэл гаргалгаа

**2.5.** Хэнтий болон Дархан политехник коллежоос үйлдвэрлэлийн дадлагыг хэрхэн явуулдаг судалгааг

## Үндэслэл

Дадлагын сургалтын өнөөгийн байдал, мэргэжлийн боловсрол сургалтын 2,5 жилээр суралцагчдын дадлагын орчин, үнэлгээ, дадлагын сургалтын үр өгөөж ямар түвшинд байгааг тогтоох, суралцагчдын нас сэтгэхүй, бие бялдрын онцлог нь тэдний үр дүнтэй суралцахад хэрхэн нөлөөлж буйд судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, үргэлжлүүлэн техникийн боловсролын ангид элсэн суралцах боломж нөхцлөөр нь хангах[1] боломж нөхцлийг судлахад оршино.

## Судалгааны ажлын зорилго, ач холбогдол

Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь мэргэжлийн боловсрол сургалтын 2,3-р курсийн оюутан суралцагчдын нас сэтгэхүйн байдал, бие бялдарын онцлог үйлдвэрлэлийн дадлага хийхэд хэрхэн нөлөөлж байгаа мөн энэ насны суралцагчдыг чанартай, үр дүнтэй суралцах нөхцлийг бүрдүүлэхэд сургалтын байгууллага, эцэг эх, ажил олгогчдын талаас хэрхэн хамтран ажиллах шаардлагатай байгааг судлахад оршино.

Уг судалгааг хийснээр мэргэжлийн боловсрол сургалтын оюутан суралцагчдын үйлдвэр сургалтын дадлагын бодит үр дүнг судлах, ажил олгогч эцэг эх, суралцагч талаас тулгардаг саад бэрхшээлүүдийг судалгаагаар гаргаж ирэх түүнд үндэслэн үйлдвэрлэлийн дадлагын үр өгөөжийг дээшлүүлэх арга замыг нээн илрүүлэх

## Судалгааны ажлын зорилтууд:

- 15-18 насны суралцагчдын нас сэтгэхүйн онцлогийг судлах
- 2,5 жилийн 2,3-р курсийн дундаж насны байдлыг 2012-2020 онтой харьцуулан судлах
- Үйлдвэрлэлийн дадлагын бааз суурь, хяналтын судалгаан дээр анализ хийх
- Үйлдвэр сургалтын дадлага хийх явцад сургууль болон суралцагч, ажил олгогч талын үүрэг хариуцлагыг судлах

[1] мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг дээд үнэлгээтэй төгсөгч нь шаталсан сургалттай техникийн боловсролын сургалтын байгууллагын дараагийн шатны сургалтад үргэлжлүүлэн суралцах

- Үйлдвэрлэийн дадлагын үр дүнг тодорхойлох, тэдний нас сэтгэхүй бие бялдрын онцлогоос шалтгаалж тулгарч буй саад бэрхшээлийг нээн илрүүлэх, үйлдвэрлэлийн дадлагын чанарыг сайжруулахад сургууль, эцэг эх, ажил олгогч талаас хэрхэн эерэг нөлөө үзүүлж буйг эрэлхийлсэн судалгаа хийх
- Оюутан суралцагчдын нас сэтгэхүй бие бялдрын онцлогт тохирсон үйлдвэрлэлийн дадлага хийх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд сургууль, эцэг эх, ажил олгогч талаас хэрхэн үр дүнтэй ажиллах шийдэл гаргалгаа олох

**Судалгааны аргууд**

- Судалгааны явцад ажиглалт хийх
- Харьцуулалтын арга
- Анкет асуулгын арга
- Нэгтгэн дүгнэх

**Нэгдүгээр бүлэг**

## 1.1 15-18 настай хүүхдийн хөгжлийн онцлог

**Бие махбодын хөгжил**

15 насны үед хөвгүүд өндөр болж, охидын өсөлт харин удааширч эхэлнэ. Биеийн хөгжлийн энэ онцлог нь их хоол идэхийг нэхэх ч гадаад байдалдаа анхаарал тавихын хэрээр их бага янз бүр хооллодог болно. Мөн өөхөн давхарга сууж эхэлдэг тул зарим нь таргалахаасаа айж хоол идэхгүй байж ч магадгүй. Гэвч хоол шиг чухал зүйл байхгүйг ойлгуулж, зөв, хооллохыг зөвлөөрэй.

Биеийн өөрчлөлт, бэлгийн хөгжил, эрүүл мэндийг сонирхоно. Энэ үед зөв, үнэн мэдээлэл, зөвлөгөө туйлын чухал бөгөөд хэрэгтэй, үнэн зөв мэдээллийг охидод ээж нь, хөвгүүдэд аав нь өгөх нь тун чухал.

## Оюун ухааны хөгжил

Сэтгэн бодох чадвар нь илт сайжирна. Тэр хэрээр хийсвэр бодол, романтик сэтгэлгээ нэмэгддэг тул шүлэг, дуу, зохиол бичиж, зураг зурж эхэлнэ. Хааяа төсөөлөлдөө автаж их бага худал ярьж магадгүй. Ийм үед нь "Зохиолч л болохгүйгээс хойш дэмий юмаар оролдлоо!" гэх мэтээр гоочилж болохгүй. Харин хөөрч худлаа ярих үед нь багахаан заль гаргаж "тэнгэрээс буулгаж, зөөлөн газардуулах" хэрэгтэй.

Сонирхол нь өргөжнө. Тиймээс хүсэл сонирхол нь ойр ойр өөрчлөгдөж магадгүй. Жишээ нь багш болно гэж ярьж байсан хүүхэд чинь хэдхэн хоногийн дараа сансрын нисгэгч болно гэж ярьж ч магадгүй. Энэ үед нь тогтворгүй, туйлбаргүй мэтээр зэмлэж болохгүй.

Тэд хүн, хүмүүсийн харилцаа, дүрэм журам, хүний амьдралын утга учир, нийгэм, хорвоо ертөнц гээд бүгдийг танин мэдэхийг чин сэтгэлээсээ хүсэж байгаа. Энэ хэрээр дүрэм журмыг эсэргүүцэж, өөрийн үзэл онолыг тогтоох гэж оролдоно. Гадуур явж, юм юмыг сонирхож, туршиж танин мэдэхийг хүснэ. Энэ үед нь "Чи юугаа мэддэг юм бэ? Мэдэх нас чинь болоогүй. Гадуур тэнэлээ. Саваагүйтлээ!" гэж загнаж болохгүй. Тэгвэл "Надад итгэдэггүй!" гэж бодох болно. Ертөнц, аливаа зүй тогтлыг танин мэдэх хүсэлд нь тулгуурлан шашны мэдлэг, зан заншлын утга учрыг ойлгуулахад тохиромжтой үе. Гэвч тулгах, сүрдүүлэх, айлгах, мухраар шүтүүлж болохгүй. Аль болох утга учрыг нь тайлбарлаж, шинжлэх ухаанчаар хүргэхийг хичээх хэрэгтэй. Шаардлагатай бол мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө аваарай.

## Нийгэмшихүйн хөгжил

Аав ээж, багшийнхаа үгэнд ордог сайн хүүхэд чинь эсрэгээрээ өөрт нь тушаасан, заасан, захирсан хүмүүст дургүй болно. Өөрийн үзэл бодолтой болж эхэлдэг тул сэтгэл санаа, үзэл бодлоо хамгаалж маргамхай болдог. Энэ үед нь "Аавын чээж гаргалаа!" гэж загнаж болохгүй. Тэд тантай тэрсэлдээгүй, оронд чинь эзэн суух

гээгүй. Зүгээр л том болж байгаагаа мэдрүүлж, мэдэрч, сэтгэлийн таашаал авч байгаа төдийхөн. Ийм үед тэвчээртэй байж, тохиромжтой үед нь эвтэйхэн тайлбарлаж хэлээрэй.

Их бухимдуу болдог. Учир нь бие нь томорч, дуу хоолой нь өөрчлөгдөнө. Гадаад байдал нь хүссэнээр нь болохгүй. Ядаж байхад батга гарна. Зарим хүн хүүхэд шиг, зарим хүн том хүн шиг харьцана. Энэ бүхэн тэдний гайхширлыг нь төрүүлж бухимдуулна. Гэвч энэ үе тийм ч их удахгүй. Эцэг эх, гэрийнхэн нь тэвчээртэй хүлээж, сайн ярилцах хэрэгтэй.

Нийгмийн мэдрэмж нь нэмэгдэж бусдыг хүндлэх, бусдын өмнө хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарлаж эхэлнэ. Энэ хэрээр гэр бүлийнхэн, дотны хүмүүстээ тулгарсан болохгүй, бүтэхгүй зүйлийн өмнө өөрийгөө буруутган эмзэглэж, гутрах нь ихэснэ. Эсрэгээрээ өөрийнх нь туслалцаатай бүтсэн ажил хэрэгт баярлаж, урам зориг, эрч хүч авна. Иймд, хэт ахадсан үүрэг хариуцлага хүлээлгэхээс болгоомжилж, өөртөө итгэх итгэлийг нь дэмжээрэй.

Маш завгүй нас. Өрөөндөө, эсвэл хаа нэг газар ганцаараа байгаа хүүхэд чинь зүгээр суугаагүй. Яагаад гэвэл тэдэнд бодох хийх юм мундахгүй их. Тэд өөрийгөө хэн болох, ирээдүйд хэн байхаа мэдэх гэж өнгөрсөн, одоо, ирээдүйгээ байнга бодно. Ялангуяа ирээдүйгээ тархиндаа бүтээхэд их цагийг зарж байгаа. Тэд бие хүн гэдгээ мэдэрч, өөрөө өөрийгөө бүтээх гэж байгаа тул та хэрэгт нь оролцох гээд хэрэггүй. Харин ч тэд танаас өөр хүн болохыг хичээж байгаа тул та аав ээжийх нь хувиар биш, үеийнх нь найзын хувиар харилцаарай. “Би чам шиг байхдаа...” гэж хэлж бүүр болохгүй. Яагаад гэвэл цаг үе өөр болсон.

Өөрийн мөн чанарыг мэдэхийн тулд юм юмыг туршихад бэлэн нас. Бусдыг дуурайх нь энгийн үзэгдэл. Дуурайх хүнээ олж ядаж байгаа энэ насныханд үлгэр жишээ болохоор хүний тухай ярьж, кино үзвэл сайн. Гэвч тулгаж болохгүй шүү.

Эрх чөлөөг тунхаглагч нас. Гэрийнхнээсээ илүү найз нөхөдтэйгөө хамт байхыг хүснэ. Яагаад гэвэл тэд өөр шиг нь бодож сэтгэх хүнийг хайж байдаг. Мөн бие хүн

болох хүсэл нь ч нөлөөлдөг. Тэр хэрээр гэрийнхнээсээ хамааралгүй байхыг хүсэж зарим нь гэрээсээ их бага хугацаагаар явж ч мэднэ. Гэвч удахгүй. Ийм үед нь уурлаж гомдолгүй хайж эрсэн хүн нь байгаад зогсохгүй үеийнх нь найз, дотны зөвлөгч нь байгаарай.

Тэдний 70 хувь нь шилжилтийн насны онцлогийн талаар эцэг эхээсээ мэдээлэл авахын хүсдэгийг эрдэмтэд тогтоосон. Тиймээс эцэг эхчүүд энэ насны онцлогийн талаар нарийн мэдээлэлтэй болж урьдаас бэлдэх хэрэгтэй. Хэрэв тэгж чадахгүй бол нэг л өдөр нэвтлэхийн аргагүй зузаан хана боссон байна гэж бодоорой. Үнэхээр тэгсэн бол сэтгэл зүйчид хандаарай.

Юм юмыг сонирхож, танин мэдэх хүсэл нь буруу замруу ч халтируулж магадгүй. Иймд мансууруулах бодис, архи, тамхи, мөрийтэй тоглоом, компьютерт донтох, цахим гэмт хэргийн золиос болох зэргийн хор гэмийг сайн таниулаарай. Гэвч хашраах, айлгах, сүрдүүлэх, торгох, шийтгэх аргыг хэрэглэж огтхон ч болохгүй. Харин өөртэй нь ярилцаж хэзээ юу хийхийг нь тогтоож, байнга завгүй байлгаарай. Энэ нь муу зүйлээс хол байх хамгийн сайн арга. Гэвч хэт шахамдуулж бас болохгүй.

## 1.2 Үйлдвэрлэлийн дадлага хийхэд сургууль, багш, ажил олгогч, эцэг эхийн эрх, үүрэг

**Уул уурхайн жишиг сургууль Говьсүмбэр Политехник коллежийн эрх, үүрэг**

1. Суралцагчдын үйлдвэрлэлийн дадлагын хуваарь, төлөвлөгөөг гарган ААНБ-д танилцуулж, батлуулсан байх

2. Дадлагажигчийг ажлын байранд дадлага хийх нөхцөлийг бүрдүүлж дадлагын хуваарийн дагуу суралцагчдыг томилох ажлыг зохион байгуулна.

3. Ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, үнэлгээ өгөх

4. Дадлага сургалтын төгсгөлд үйлдвэрлэлийн дадлага сургалтын төрөл, хугацаа, сурсан үйл ажиллагаа, олж авсан чадамжийг тодорхойлж баталгаажуулт хийх

5. Дадлагажигчийн дадлага хийх хугацаанд хяналт тавьж ажиллах.

6. МБСБ нь дадлагажигч, дадлагажуулагч багшийг ААНБ-тэй зөвшилцөж бэлтгэсэн дадлагын удирдамжаар хангасан байх.

7. Дадлагажигчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байх

8. ААНБ-гаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

**ААНБ-ийн эрх, үүрэг**

1. Дадлагажигчийг дадлагын хөтөлбөрийн дагуу дадлага хийх нөхцөлөөр хангах: Өөрөөр хэлбэл тодорхой хуваарийн дагуу хэсэг нэгж, дамжлага бүртэй танилцуулж дадлагажуулах

2. Дадлагын удирдагчийг томилох

3. Дадлагын ажилд гарах дадлагажигчдад байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг танилцуулж, өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч гарын үсэг зуруулж байх.

4. Дадлагажигчид дадлагын ажилд хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмж, бусад эд зүйлстэй ажиллах зааварчилгааг өгөх.

5 Зөвхөн сургалт, дадлагын зорилгод нийцсэн ажлын даалгаварыг дадлагажигчдад өгөх.

6. Сургалт, дадлагын хөтөлбөрийн дагуу холбогдох материал цуглуулж судалгаа хийхэд нь туслалцаа үзүүлэх.

7. Дадлагажигчийн ирц, дадлагын ажлын оролцоонд хяналт тавих.

8. Дадлагажигчийг ажлын байранд гэмт халдлагад өртөхгүй байх нөхцлийг хангах

9. Дадлагын хугацаанд байнга цэвэрлэгээний ажилд оролцуулахгүй байх

10. УУЖС Говьсүмбэр Политехник коллежоос гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

11. Дадлагажигчид цалин олгож болно.

12. Дадлагажигч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дадлагын ажил таслах, ажлын байрны дүрэм, журмыг зөрчих, ажлын байранд зүй бус үйлдэл гаргавал дадлагажигчийн дадлагын ажлыг зогсоох эрхтэй.

13. Дадлагажигчийн дадлагын ажлын гүйцэтгэлд үнэлгээ, дүгнэлт хийх эрхтэй.

14. Дадлагын удирдагчийн зааварчилгааг дагаж мөрдөөгүй дур мэдэн техник хэрэгсэл ажиллуулсан, байгууллагын аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөн дадлагажигчаас үүссэн хохиролыг нэхэмжлэх эрхтэй.

15 Дадлагажигчид хоол, унаа болон цалин урамшуулалыг журмын дагуу олгож болно.

**Дадлагажигчийн эрх, үүрэг**

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн анхан шатны зааварчилгааг авч аюулгүй техникийн дүрмийг судлан нарийн чанд баримтлан мөрдөх

2. ААНБ-ийн дотоод дүрэм, журмыг чанд сахин биелүүлж УУЖС Говьсүмбэр Политехник коллежийн оюутан, суралцагчдын нэр хүндийг хангах

3. Дадлагын хугацаанд сургалт, дадлагын хөтөлбөрийн дагуу эзэмших шаардлагатай мэргэжлийн болон ажил эрхлэх ур чадварт суралцаж, биеэ дайчлан ажиллах.

4. Хөдөлмөр хамгаалалын хувцас, хэрэгслийг өөрөө бэлтгэх.

5. Онолын мэдлэгээ баталгаажуулахын төлөө шинийг эрэлхийлж идэвхи санаачлагатай ажиллах

5. Тоног төхөөрөмжийн ажиллагаа болон техникийн баримт бичигтэй танилцаж дадлагын ажлын талаар өдөр тутмын тэмдэглэл хөтөлж дадлага удирдаж байгаа ажилтанд хянуулах

6. Тухайн ААНБ -ийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад эд зүйлсийг ариг гамтай хэрэглэх.

7. Дадлагын тайланг зааврын дагуу бичиж хамгаалах

8. Дадлагын хугацаанд ажлын цаг баримтлах, шалтгаангүй таслахгүй байх.

9. Гэнэтийн ослын даатгалд хамрагдсан байх

10. Зөвхөн урьдчилан авсан зөвшөөрлийн дагуу үйлдвэрлэлийн дадлагын ажлаас чөлөөлөгдөх ба чөлөө авах шалтгаанаа заавал мэдэгдэх.

11. Насанд хүрээгүй дадлагажигчийн хувьд түүний асран хамгаалагч (эцэг, эх гэх мэт) түүний гэрээгээр хүлээсэн үүрэг даалгаварын биелэлтийг хариуцах.

12. Боловсролын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт заасан эрхийг эдэлнэ.

13. МБС-ын тухай хуулийн 17.1.2 заасны дагуу үйлдвэрлэл үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ үндсэн болон дагалдангийн орон тоон дээр ажилласан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт авах эрхтэй.

## Хоёрдугаар бүлэг - Судалгааны хэсэг

### 2.1 2010-2012 оны төгсөгчдийн насны байдлыг 2019-2020 онд төгсөж буй төгсөгчдийн насны байдалтай харьцуулан судалсан судалгаа

Ерөнхий боловсролын сургуулиуд 2008 оноос 12 жилийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагат элсэн суралцахаар ирж буй суралцагчдын нас 14-15 нас болсон билээ.

Үүнийг хүснэгтээр харуулвал:

2011-2012 он 1-р курс

| № | Овог нэр | Хүйс | Нас | Регистрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | Билэгдэмбэрэл Алтангэрэл | 1 | 15 | КИ93121310 |
| 2 | Түвшинтөр Амартүвшин | 1 | 16 | ЛЖ93041410 |
| 3 | Эрдэнэбат Ариунбуян | 1 | 16 | ЗИ94102327 |
| 4 | Сүхбат Элбэгбаяр | 1 | 17 | ВМ92040137 |
| 5 | Энхжаргал Мягмарсүрэн | 1 | 16 | ЕА93031612 |
| 6 | Батсуурь Мөнхбат | 1 | 24 | ЗН85031916 |
| 7 | Буянбат Эрдэнэбат | 1 | 17 | ЕА92011213 |
| 8 | Батжаргал Дэлгэрсүрэн | 1 | 17 | ЗБ92081314 |
| 9 | Төмөрбаатар Ганхөлөг | 1 | 17 | УШ92102151 |
| 10 | Алтанхуяг Мөнхбаатар | 1 | 16 | ЗБ93052711 |
| 11 | Хишигжаргал Өлзиймөр | 1 | 16 | ТГ93101517 |
| 12 | Баярсайхан Энхсайхан | 1 | 17 | ЗИ92081616 |
| 13 | Цагаан Бат - Эрдэнэ | 1 | 16 | ЕИ94020116 |
| 14 | Урангэмэл Содбаяр | 1 | 16 | ЕА93101617 |
| 15 | Эрдэнэтуяа Гантулга | 1 | 16 | ЗИ93011114 |
| 16 | Ганболд Үүганболд | 1 | 22 | МС87011813 |
| 17 | Ганбаатар Цэндиг | 1 | 15 | ЗГ93062417 |
| 18 | Баярсайхан Эрдэнэ-Очир | 1 | 16 | УП93030953 |
| 19 | Эрдэнэхуяг Хуягбаатар | 1 | 16 | ЕО94112216 |
| 20 | Ариунтуяа Бат-Эрдэнэ | 1 | 15 | ЕА94042915 |
| 21 | Охин Мягмар | 1 | 22 | ЦЕ87101910 |
| 22 | Баттөр Жамбалдаваа | 1 | 16 | ДВ94041017 |

2020-2021 төгсөх анги

| № | Ургийн овог | Овог | Нэр | Регистрийн дугаар | Нас | Хүйс |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Боржигон | Нямсүрэн | Алтангэрэл | ЕЙ03291511 | 17 | эр |
| 2 | Боржигон | Батболд | Бат-Эрдэнэ | ЛБ02300418 | 18 | эр |
| 3 | Боржигон | Ганболд | Гантөмөр | ЕЙ02261717 | 18 | эр |
| 4 | Боржигон | Нэргүй | Жамъян | ЗГ03282311 | 17 | эр |
| 5 | Боржигон | Дашдорж | Мөнхтулга | ЗБ03270418 | 17 | эр |
| 6 | Боржигон | Нармандах | Мөнх-эрдэнэ | ЕН03282310 | 17 | эр |
| 7 | Боржигон | Хүрэлбаатар | Мягмарцэнд | НЕ03260311 | 17 | эр |
| 8 | Боржигон | Мөнхцэцэг | Нэргүйбаатар | ФД03210619 | 17 | эр |
| 9 | Боржигон | Энхтөр | Отгонбаяр | ЗБ03271912 | 17 | эр |
| 10 | Боржигон | Түмэнжаргал | Түвшинжаргал | ЕЙ03301316 | 17 | эр |
| 11 | Боржигон | Цэрэннадмид | Чойжамц | ЗБ03270110 | 17 | эр |
| 12 | Боржигон | Ариунтунгалаг | Энхжаргал | ЗВ02220614 | 18 | эр |
| 13 | Боржигон | Эрдэнэчулуун | Эрдэнэбат | МЮ02302913 | 18 | эр |
| 14 | Боржигон | Энхбаяр | Эрдэнэзөрөн | УЦ03231157 | 17 | эр |
| 15 | Боржигон | Буяндалай | Өсөхбаяр | ЕЙ03320118 | 17 | эр |
| 16 | Боржигон | Болдсайхан | Булганбаяр | ЕЙ02253015 | 18 | эр |

### 2.2 Өөрийн сургуулийн багш нараас үйлдвэрийн дадлагын үр дүн болон түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг нээн илрүүлэх, манай МБС-ын 2,3-р курсийн оюутан суралцагчдын нас сэтгэхүй бие бялдар үйлдвэрлэлийн дадлага хийх болон ажлын байранд гарахад тохиромжтой эсэхийг судалсан судалгаа

**Асуулт 1**

Мэргэжлийн боловсрол сургалтын 2,3-р курсийн оюутан суралцагчид ҮД-ыг хэдэн хувийн үр дүнтэй хийж байна гэж үзэх вэ?




Судалгаанаас харахад багш нарын 50%-иас илүү хувь нь үйлдвэрлэлийн дадлагын үр дүнг 50-60 хувьтай гэж үзэж байна. Зарим мэргэжлийн багш нар дадлага хийсэн байдаг ч үр дүн нь тийм ч хангалттай бус байдаг гэж үздэг нь харагдаж байна.

**Асуулт 2**

Үйлдвэрлэлийн дадлагыг чанартай үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлж буй хүчин зүйлсийг дугуйлна уу!




Судалгаанаас харахад үйлдвэр сургалтын дадлага хийхэд мэргэжлийн багш болон хяналт тавих хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна. Мөн тэдний нас 15-17 буюу насанд хүрээгүй байдаг тул дадлага ажлын үр дүнд нөлөөлдөг гэж үзсэн байна.

зэрэг дутагдал байна. Мөн хараа хянал байхгүйгээс оюутнууд дадлагаа таслах, цаг барьдаггүй, ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцдэггүй зэрэг асуудлууд байдаг нь харагдаж байна. Тиймээс цаашид бид үйлдвэрлэлийн дадлагыг чанаржуулах, үр дүнг сайжруулахын тулд сургуулийн зүгээс оюутан суралцагчдынхаа нас, бие бялдрын онцлогийг судлан үзэж түүнд тохирсон удирдамж даалгаврыг боловруулах, түншлэгч байгууллага дадлага хийх газрын хүртээмжийг сайжруулах, нэг хүүхэд гэхгүй гэрээ контрактыг байгуулж хяналт тавих, оюутан суралцагчидаа дадлага хийх явцад нь бүхий л талаас нь тусалж дэмжих дадлага удирдах багш ажилтнаар хангах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Мөн түүнчлэн 2,5 жил сураад төгсөхдөө оюутнуудын 60 аас илүү хувь нь насанд хүрээгүй буюу 17 настай оюутнууд байдаг нь судалгаагаар харагддаг. Тиймээс Мэргэжлийн боловсролын тухай хуулийн 17.1.3 заалтыг[3] үндэслэн цаашид дэвшин суралцах боломж нөхцлийг бүрдүүлэх мөн суралцах хугацааг 3 жил болгох тал дээр сургуулийн зүгээс санал оруулах шаардлагай гэж үзэж байна.

**Дэвшүүлэх санал**

- Насны байдлыг харгалзан үзэж үйлдвэр дадлагын газар, дадлага хийх орчноор хангаж өгөх
- Үйлдвэрлэлийн дадлага хийх аж ахуй нэгж, компаниудын тоог нэмэгдүүлж албан ёсны гэрээ байгуулж хамтран ажиллах
- Сургуулийн зүгээс хамгийн багадаа 7 хоногийн хугацаатай мэргэжлийн багш нараар дадлагийг удирдуулах
- Мөн сургуулийн зүгээс тавих хяналтыг сайжруулах. Зөвхөн ангийн багш болон ҮСД хариуцсан ажилтан бус мэргэжлийн багш, ХАБ-ын ажилтан хяналт тавих, биечлэн очиж шалгаж байх
- Сургууль өөрөө дадлагын баазтай болох ажлыг яаралтай эхлүүлэх

[3] мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг дээд үнэлгээтэй төгсөгч нь шаталсан сургалттай техникийн боловсролын сургалтын байгууллагын дараагийн шатны сургалтад үргэлжлүүлэн суралцах

## Ашигласан ном материал


1. Мэргэжлийн боловсролын тухай хууль
2. Мэргэжлийн боловсхол, сургалт зорилт үйл ажиллагаа үр дүн ном 2012
3. Дадлагын судалгааны нэгдсэн тайлан 2020 оны намар
4. www. Google.com
5. Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2010-2019 оны статистик мэдээ
6. Чанартай сургалт- чавдарлаг мэргэжилтэй ажилтан 2015 он
7. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх зөвлөмж 2016 он




Нийт дадлагачигчдийн 39 суралцагч буюу 19.7% нь “Шивээ овоо” ххк-д дадлага хийсэн бөгөөд оюутнуудыг дадлага гарах хугацаатай зэрэгцэн хамтран ажиллах гэрээний хугацаа дууссан байсан ба Гадаад харилцааны ажилтан Д.Мөнхбаяр, Арга зүйч Ц.Мягмарсүрэн, Дадлагын ажилтан Б.Мандах нар тус байгууллагын хүний нөөцийн менежер, хуульчтай холбогдож хамтран ажиллах дадлагын гэрээг сунгах оюутнуудыг үргэлжлүүлэн дадлагажуулахаар болсон байна. Орон нутагт 23 буюу 11,67% нь, Томоохон үйлдвэр уурхайн газарт 11 суралцагч буюу 6%, орон нутгийн эмнэлэг болон сургуулийн барилгад 22 суралцагч буюу 11,1% дадлага хийсэн ба цахилгааны багш Л.Мөнхжаргал дадлагын ажилтан Б.Мандах нар барилгын хариуцагч албан тушаалтантай тохиролцож дадлагажуулахаар болсон байна. Мөн 19 суралцагч буюу 9,6% нь Улаанбаатар хотод, Дорноговь аймгийн даланжаргалан сумын ойролцоох үйлдвэр уурхай чулуун заводын үйлдвэрт нийт 11 суралцагч буюу 5.5% суралцагч, бусад гэсэн тодорхойлолтонд 30 суралцагч буюу 15,2% нь хувийн аж ахуй нэгжид үүнээс 10 суралцагчийг “Петротрак” ххк-тай шинээр гэрээг сунгаж байгуулж ажилласан байна. Хувийн аж ахуй нэгжид мөн адил 30 суралцагч буюу 15,2% нь дадлагажсан ба сурлцагчдыг аж ахуй нэгж байгууллагуудтай холбож ажилласан байна. Нийт 71 суралцагч буюу 36% нь сургуулийн дадлагын ажлын хүрээнд аж ахуй нэгж байгууллагуудтай холбож өгсөн байна. Үлдсэн 64% нь өөрсдөө аж ахуй нэгж байгууллагуудтай холбогдож дадлагын баазаа олсон байна.




# Дадлагын хяналт ба ирцийн мэдээллийн судалгаа

| № | Багш нарын нэрс | Даасан анги | Дадлага хийх хугацаа | Ангийн суралцагчдийн тоо | тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | С.Сүндэрмаа | ХММО 3А | 09.01-10.30 | 18 | Хариуцсан |
| 2 | А.Оюунгэрэл | ХММО 2А | 09.14.-10.30 | 17 | Хариуцсан |
| 3 | Ц.Мөнхцэцэг | ХММО 2Б | 09.14-10.30 | 16 | Хариуцсан |
| 4 | А.Чулуунчимэг | ХММО 3в | 09.14-10.30 | 16 | Хариуцсан |
| 5 | А.Золжаргал | ХММО 2г | 09.14-10.30 | 14 | Дикриттэй байсан |
| 6 | М.Баярмаа | ХММО 2в | 09.14-10.30 | 16 | Хариуцсан |
| 7 | М. Чулуунцэцэг | Гагнуур 3а | 09.01-10.30 | 7 | Хариуцсан |
| 8 | Б. Мөнхбаясгалан | ХММО 3Б | 09.01-10.30 | 18 | Хариуцсан |
| 9 | Ц.Энхтөр | БЦ 3а | 09.01-10.30 | 14 | Хариуцсан |
| 10 | Л. Мөнхжаргал | НСО 2а | 09.14-10.30 | 10 | Хариуцсан |
| 11 | Ц. Намсрай | Авто 2а | 09.14-10.30 | 10 | Хариуцсан |
| 12 | Т.Эрхэмбаяр | Гагнуур 2а | 09.14-10.30 | 8 | Хариуцсан |
| 13 | Б. Бүүвэйхүү | ХММО 3г | 09.01-10.30 | 20 | Хариуцсан |
| 14 | Б.Будханд | БЦ 2а | 09.01-10.30 | 15 | Л.Мөнхжаргал багш |